



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 18 өдөр

Дугаар А/442

Ховд

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай


Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.3, 38.4 дэх заалт, Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоол, Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 143 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын Цамбагарав баг хуучнаар шүүхийн нэгдсэн контор байрлах үйлчилгээний зориулалттай Жаргалын Лхамжав /ОГ70122306/-ийн эзэмшлийн 1760 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Баяраагийн Болорцэцэг /ПБ81071302/-д кадастрын мэдээллийн сангийн зургийн дагуу 1803 метр квадрат, хаягийг Заны 1 дүгээр гудамжны 103 тоот болгон 6 жилийн хугацаагаар,

2. Жаргалант сумын Рашаант баг Эрх чөлөө 2 дугаар гудамжны 231 тоотод байрлах худалдаа, үйлчилгээний зориулалттай “Алтайн аянчин” ХХК /2033186/-ийн эзэмшлийн 28506 метр квадрат газраас 1040 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Бямбаагийн Бат-Оргил /ПЮ93070317/-д худалдаа, үйлчилгээний зориулалтаар, хаягийг Эрх чөлөө 2 дугаар гудамжны 231 а тоот болгон 6 жилийн хугацаагаар, үлдсэн 27466 метр квадрат газрыг “Алтайн аянчин” ХХК /2033186/-д 6 жилийн хугацаагаар тус тус шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

3. Газар эзэмших эрхийг хуулийн дагуу шилжүүлэн авч, газраа зориулалтын дагуу үр ашигтай, зүй зохистой эзэмшиж, ашиглаж, хамгаалж, газар эзэмшүүлэх гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлж ажиллахыг дээрх иргэн, аж ахуй нэгжид үүрэг болгосугай.

4.Газар эзэмших эрх нь баталгаажсан иргэн, аж ахуй нэгжтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Э.Дөлбадрал/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Б.ДҮГЭРЖАВ

